

БАТЛАВ:


СУМЫН ЗАСАГ ДАРГА
М.БАЯРСҮХ


“БЭЛЧЭЭР ХАДЛАН СУДЛАЛЫН
НИЙГЭМЛЭГ” ТӨРИЙН БУС
БАЙГУУЛАГЫН ТӨРГҮҮН
Ж.УНДАРМАА

МАЛЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА, ЗӨВЛӨХ

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ

№ДУГАДЦСЗДТГ/202301005

2023 оны 02 сарын 03 өдөр

Улаанбаатар

ХОТ

Нэг талаас Дундговь аймгийн Дэлгэрцогт сумыг төлөөлж СЗДТГ-ын дарга Сугарын Нарантунгалаг /цаашид захиалагч гэх/ нөгөө талаас малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан бэлчээрийг зохистой ашиглах, сайжруулах, малыг тэжээх, үүлдэр угсааг сайжруулах, малын халдварт, гоц халдварт өвчин, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, үлийн цагаан оготнотой тэмцэх аргын талаар мэдлэг эзэмшүүлэх сургалт зохион байгуулах ажлыг гүйцэтгэхээр “Бэлчээр хадлан судлалын нийгэмлэг”, түүнийг төлөөлж Зоригбаатар овогтой Нямцэрэн /цаашид Ажил гүйцэтгэгч гэх/ нарын хооронд харилцан тохиролцож 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдөр байгуулав.

НЭГ. Ерөнхий зүйл

1.1. Малчдад малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан бэлчээрийг зохистой ашиглах, сайжруулах, малыг тэжээх, үүлдэр угсааг сайжруулах, малын халдварт, гоц халдварт өвчин, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, үлийн цагаан оготнотой тэмцэх аргын талаар мэдлэг эзэмшүүлэх сургалт зохион байгуулах ажлыг зохион байгуулах үйл ажиллагааны талуудын хоорондын төлбөр тооцоо, эрх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулахад тус гэрээний зорилго оршино.

1.2. Доор дурдсан бичиг баримтууд гэрээний салшгүй хэсэг болно.

Үүнд:

Хавсралт 1. Сургалтын төсөв

Хавсралт 2. Сургалтын хөтөлбөр

ХОЁР. Гэрээний хугацаа

Энэхүү гэрээ нь 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс 03 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хүчинтэй. / Гэрээ нь хоёр тал харилцан зөвшөөрч гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба ажил үүргээ бүрэн биелүүлсэн, гэрээ дүгнэгдсэн нөхцөлд дуусгавар болно/

ГУРАВ. Гэрээний төлбөр

3.1. Хамтран ажиллах гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт зардал нь 2,514,000 /хоёр сая таван зуун арван дөрвөн мянга таван зуу/ төгрөг байна.

3.2. Хамтран ажиллах гэрээний хавсралтаар батлагдсан сургалтыг зохион байгуулаагүй, төлөвлөсөн үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй, үйл ажиллагааны тайлан шаардсан мэдээллийг тусгаагүй байгаа зэргийг баримтаар нотолсон нөхцөлд үйл ажиллагааг дахин хэрэгжүүлэх, тайланд тавигдсан шаардлагыг хангуулах үүднээс дахин засварлах, сайжруулах, бүрэн дуусгахыг шаардах бөгөөд энэ нь тухайн ажлын төлбөрийг төлөх үндэслэл болно.

3.3. Гэрээний 3.1 дүгээр хэсэгт заасан үнийн дүн зөвхөн сургалтын төлбөр бөгөөд энэ үнийн дүнд суралцагчдын дадлага хийх үеийн байр, хоол, тээврийн зардал ороогүй болно.

3.4. Гэрээгээр гүйцэтгэх ажлын гүйцэтгэл тус бүрээр тайлан хүлээн авсаны дараа төлбөрийг “Бэлчээр хадлан судлалын нийгэмлэг” ТББ-ын ХААН банкны 5622377689 тоот дансанд шилжүүлэх бөгөөд сургалтын үйл ажиллагааны зарцуулагдах хөрөнгийн 80 хувьтай тэнцэх дүнг батлагдсан зардлын задаргааны дагуу тухайн үйл ажиллагаа эхлэхэд, үлдэгдэл 20 хувийг сургалтын тайлан ирүүлсний дараа нэхэмжлэлийг үндэслэн тус тус шилжүүлнэ.

3.5. Гэрээт ажлын төлбөрийн дүнгээр И баримтыг төслийн нэгжид өгнө. И баримт өгөөгүй тохиолдолд 10 хувийг суутгана.

ДӨРӨВ. Захиалагчийн эрх, үүрэг

4.1. Захиалагч нь гэрээт хугацааны ажлын даалгавар, төлөвлөгөө, хуваарийн дагуу ажил үүргээ чанартай гүйцэтгэхийг шаардах эрхтэй.

4.2. Захиалагч нь гэрээний төлбөрийг гэрээнд заасан санхүүжилтийн хуваарийн дагуу хийх үүрэгтэй.

4.3. Захиалагч нь ажил үйлчилгээний хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг шаардлагатай үед гаргуулж авах, мөн өөрийн төлөөллийг сургалт, семинар зэрэг ажилд оролцуулах эрхтэй.

4.4. Захиалагчийг төлөөлж ТХН-ийн аймаг, суман дахь төслийн ажилтнууд нь холбогдох заавар, журмын дагуу ажлын явц, хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх эрхтэй байна.

4.5. Ажил гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн гэрээг цуцлахад үүсэх нөхцөл байдалд захиалагч ямар нэгэн санхүүгийн хариуцлага хүлээхгүй бөгөөд зөвлөх тухайн ажилд зориулан авсан санхүүжилтийг захиалагчид 100% буцаан шилжүүлэх үүрэгтэй.

ТАВ . Гүйцэтгэгч талын эрх, үүрэг

- 5.1. Ажил гүйцэтгэгч нь гэрээнд заасан ажлыг цаг хугацаанд нь тоо хэмжээгээр нь мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх үүрэгтэй.
- 5.2. Гэрээт ажлуудыг хийх компани, аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэлд төлөвлөгөөний дагуу хяналт тавьж ажиллах, ажлын тайлан мэдээг суралт хийснээс хойш ажлын 5 өдрийн дотор гаргаж захиалагч талд хүргүүлнэ.
- 5.3. Сургалтыг зохион байгуулахдаа Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын бэлчээр хариуцсан мэргэжилтэн, газрын даамал, ХАА-н тасгийн мэргэжилтэн, Сумын Засаг дарга, Бэлчээр ашиглагч малчдын бүлгийн малчдыг хамруулна.
- 5.4. Гэрээт ажлыг гүйцэтгэх нийт зардлын тооцоог гаргаж, захиалагч талаас баталсан зардлын хүрээнд хийнэ.
- 5.5. Ажил гүйцэтгэх явцад ажлын гүйцэтгэлийг захиалагчаар хянуулж, тавьсан шаардлагыг биелүүлнэ.
- 5.6. Төслийн дотоод үйл ажиллагаа, санхүүгийн холбогдолтой аливаа мэдээллийг бусдад ярихгүй байх, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл өгөхгүй байх үүрэгтэй.
- 5.7. Оролцогч талуудыг идэвхжүүлэх, зохион байгуулж буй үйл ажиллагааныхаа уялдаа холбоог сайжруулах үүднээс Захиалагчийн хэрэгжүүлж буй бусад үйл ажиллагааны талаар мэдээлэл авах эрхтэй.
- 5.8. Гүйцэтгэгч нь өөрийн хэрэгжүүлсэн ажлын чанар, хэрэгжилтийг бүрэн хариуцах ба Захиалагч үзүүлсэн дэмжлэгүүдтэйгээ холбоотойгоор ажлын чанарт ямарваа нэг хариуцлага хүлээхгүй.
- 5.9. Гүйцэтгэгч нь ажлын явц болон гүйцэтгэлийн тайланг гэрээт хугацаанд гаргаж төслийн тавьсан шаардлагын дагуу ирүүлнэ.
- 5.10. Сургалтын дадлага хийгдэх үеийн оролцогчдын байр, хоол, тээвэр нь шаардлага хангахгүй байвал орчин нөхцлийг сайжруулахыг шаардах эрхтэй.

ЗУРГАА. Бусад зүйл

- 6.1. Талууд ажил гүйцэтгэхтэй холбоотой асуудлаар албан бичгээр, шуудангаар, цахим шуудангаар, факсаар харилцана.
- 6.2. Маргаанаас зайлсхийх, эсхүл түүнийг цаг алдалгүй шийдвэрлэх нь гэрээний гүйцэтгэлийг сайтар хангах болон төсөл арга хэмжээний амжилтанд ихээхэн чухал гэдгийг талууд хүлээн зөвшөөрнө.
- 6.3. Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан тохиролцож, эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх ба шийдэлд хүрч чадахгүй нөхцөлд маргааныг зохих шатны шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.
- 6.4. Талууд гэрээний баримт бичигт төсөл хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан шаардлагын дагуу нэмэлт өөрчлөлт оруулж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагчийг төлөөлж:

СЗДТ-ын дарга С.Нарантунгалаг

МЭ-ийн тасгийн дарга

Ажил гүйцэтгэгчийг төлөөлж:

“Бэлчээр хадлан судлалын
нийгэмлэг” ТББ-ын ажилтан

З.Нямцэрэн *Нямцэрэн*

Д.Наранцэцэг
ХАА-н мэргэжилтэн

Б.Баттогтох
Захиалагчийн хаяг:
Дундговь аймгийн Дэлгэрцогт
сум 3-р баг

Утас: 94889922



Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө гудамж, ХТК байр, 221 тоот

Mobile: 99050690

E-tail: j_undarmaa@mul.s.edu.mn

2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн

СУРГАЛТЫН НЭГДСЭН ХӨТӨЛБӨР

2023 оны 03 дүгээр сарын 04	
10:00-10:10	Нээлт Дундговь аймгийн Засаг Дарга Дэлгэрцогт сумын Засаг Дарга
10:10-10:40	Шагнал гардуулах
10:40-10:50	Урлагийн үзүүлэлт
10:50-11:00	Сургалт явуулах багш нарын танилцуулга
11:00-12:40	Бэлчээр зохистой ашиглах, сайжруулах аргууд <i>Доктор, профессор Ж.Ундармаа, ХААИС, Агроэкологийн сургууль, Экосистемийн судалгааны төвийн захирал</i>
12:40-13:00	Асуулт, хариулт
13:00-14:00	Өдрийн хоол
14:00-15:00	Малын өвчин, эмчлэх, урьдчилан сэргийлэх аргууд <i>Доктор Б.Пүрэвцэрэн</i>
15:00-16:00	Малын тэжээл бэлтгэх, малын үүлдэр угсаа сайжруулах аргууд <i>Доктор Д.Лхагважсав</i>
16:00-17:00	Үлийн цагаан оготны өсөлт, хөгжилт, тэмцэх арга <i>Доктор Д.Цэвээндорж</i>
17:00-17:10	Сургалтын хаалт